

“САРУУЛ ТАЛ” ДУУНЫ ХУВИЛБАРТ ХИЙСЭН АЖИГЛАЛТ (ХОЁР АЛДАРТ УРТЫН ДУУЧНЫ ДУУЛСАН ЖИШЭЭН ДЭЭР)

Дай.Цацрал¹
Ц.Чулуунцэцэг^{2,*}

¹ Соёл урлагийн их сургуулийн Хөгжмийн урлагийн сургуулийн докторант,
Улаанбаатар, Монгол улс

² Доктор (Ph.D), дэд профессор, Соёл урлагийн их сургууль, Улаанбаатар, Монгол улс

*Corresponding author: chuka0588@gmail.com

Хураангуй: Монгол уртын дуу нь монгол туургатны хэмжээнд тархсан байдаг. Гэвч нутаг нутгийн уртын дуу дуулах арга барил, орон нутгийн өвөрмөц байдал нь өөр өөрийн онцлогийг хадгалж байдаг. Монгол улсад болон Өвөр Монголд өөр аяар дуулагддаг, адилхан нэртэй уртын дуунууд нэлээд олон байдаг. Тухайлбал, “Саруул тал” дуу нь олон хувилбараар Монгол улсад болон Өвөр Монголд тархсан байдаг. Өвөр Монголын алдарт уртын дуучин Н.Буяндэлгэрийн Барга хувилбараар дуулсан “Саруул тал” дууг авч үзэхээс гадна Монгол улсын алдарт уртын дуучин Н.Норовбанзадын дуулсан “Саруул тал” дууны хувилбартай жишин харьцуулж, улмаар хоёр алдарт уртын дуучны дуулах онцлог шинжийг тодорхойлохыг зорилоо.

Түлхүүр үг: Н.Буяндэлгэр, Н.Норовбанзад, дуулах онцлог, барга

AN OBSERVATION OF THE VERSIONS OF THE LONG-SONG “SARUUL TAL” (ON THE EXAMPLE OF SINGING BY TWO FAMOUS SINGERS)

Tsatsral Dai¹
Chuluuntsetseg Tseren^{2,*}

¹ Doctoral student of School of Music Arts, Mongolian National University of Arts and Culture,
Ulaanbaatar, Mongolia

² Doctor (Ph.D), Associate Professor, Mongolian National University of Arts and Culture,
Ulaanbaatar, Mongolia

*Corresponding author: chuka0588@gmail.com

Abstract: The Mongolian long-songs are popular among the Mongolian nationalities. But the local long-song singing techniques and special features are distinctive. There are many long-songs with the same name which are differently sung in Mongolia and Inner Mongolia. For example, the song “SaruulTal” has been distributed in many versions in Mongolia and Inner Mongolia. We aimed to determine their singing special



features, comparing the bargu version of the song “Saruul Tal”, sung by the famous Inner Mongolian singer N.Buyandelger with the version of the same song, sung by the famous Mongolian singer N.Norovbanzad.

Key words: N. Buyandelger, N. Norovbanzad, special singing feature, bargu

Үндсэн хэсэг

Нэг. Хоёр алдарт уртын дуучны намтар, уран бүтээлийн товчоон

Намжилын Буяндэлгэрийн товч намтар, уран бүтээл: Намжилын Буяндэлгэр (1933-2013) нь БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөлөнбуйрын Шинэ барга зүүн хошуунд мэндэлжээ. Монгол үндэстний уртын дууны олон удаагийн аварга, дуу хөгжмийн сурган хүмүүжүүлэгч, орчин цагийн анхны мэргэжлийн дуу хөгжмийн урлагийн гол төлөөлөгч мөн. Үндэстний уртын дууны соёлын биет бус өвийн өвлөн уламжлагч, монгол үндэстний уртын дууны Барга хэв намбын голлох төлөөлөгч (Уртын дууны хатан хаан Н.Буяндэлгэр баримтат кино, 2016) хэмээн тэмдэглэжээ. Тэрбээр Өвөр Монголын дуу бүжгийн уран бүтээлчдээс анх тэргүүлэн 1955 онд “Дэлхийн алтан медаль”, 1978 онд “Улсын тэргүүн зэргийн жүжигчин цол” хүртэгч, 1988 онд “Улсын эрдэнэ”, 1989 онд “Дархан дуучин”, 2000 онд “Монгол үндэстний соёлын залгамжлах жишээч”, 2008 он, “Монгол үндэстний уртын дууны соёлын биет бус өвийн өвлөн уламжлагч”, 2013 онд БНХАУ-ын Соёлын яамнаас “Хятадын биет бус соёлын өвийг залгамжилсан Шин Цюан” шагнал хүртсэн юм. Н.Буяндэлгэрийн урлагийн авьяас бага наснаас тодорч, зургаан насандаа дуулах болж, долоон наснаас ааваараа дуу заалгаж эхэлсэн юм. Н.Буяндэлгэрийн урын санд “Саруул тал”, “Нарийхан халиун”, “Танжуурын бүрд”, “Дүүрэн заан”, “Сэргэлэнхэн уул”, “Баян баргын манаа”, “Соёг бор”, “Эр бор харцага”, “Улаан нар”, “Миний нутаг”, “Өвөр Монгол сайхан”, “Данаабал” зэрэг барга уртын дуунууд голлодог. Бид “Саруул тал” дууг сонгон авсан болно.

Намжилын Норовбанзадын товч намтар, уран бүтээл: Намжилын Норовбанзад (1931-2002) нь Дундговь аймгийн Дэрэн сумын уугуул, Монгол улсын Хөдөлмөрийн баатар, Ардын жүжигчин, Төрийн шагналт уртын дуучин юм. Тэрээр 1957 онд Москва хотноо болсон Дэлхийн оюутан, залуучуудын их наадмаас алтан медаль хүртэж, дуучны гараагаа амжилттай эхлүүлжээ. 1993 онд Японы Фүкүокагийн “Азийн соёлын шагнал”-ыг хүртсэн. Монгол уртын дууг дэлхий дахинд таниулсан түүний гавьяаг үнэлж, 1961 онд Гавьяат жүжигчин, 1969 онд Ардын жүжигчин, 1984 онд Төрийн шагнал, 1999 онд Монгол улсын Хөдөлмөрийн баатар цолоор шагнажээ. Түүний урын санд Монгол ардын уртын дууны охь болсон “Сэрүүн сайхан хангай”, “Уяхан замбуутивийн наран”, “Урьхан хонгор салхи”, “Дөмөн”, “Энх мэндийн баяр”, “Хэрлэнгийн барьяа”, “Түмэн эх”, “Өвгөн шувуу хоёр”, “Бор борын бялуухай”, “Саруул тал” зэрэг дуунаас гадна монгол ардын богино дуу “Баян Монгол”, “Үхэрчин хүү”, “Үлэмжийн чанар”, “Манарч байгаа шил”, “Танган хар морь”, “Тоолингоо”, “Ян тайван гөөгөө” зэрэг дуу, түүнчлэн “Дөрвөн цагийн тал”, “Монгол нутгийн үзэсгэлэн” зэрэг дуунууд багтдаг. “Сэрүүн сайхан хангай” дуу нь түүний дуулснаар ЮНЕСКО-д бүртгэгджээ. Ард түмний дунд хамгийн алдаршсан дуу нь “Уяхан замбуутивийн наран” мөн (Норовбанзад, 2016, 215).

Хоёр. Хоёр алдар уртын дуучны дуулсан “Саруул тал” дуунд хийсэн ажиглалт

Н.Буяндэлгэрийн дуулсан “Саруул тал” дуу: “Саруул тал” дуу 1886 онд одоогийн ӨМӨЗО-ны Барга, Зүүн гарам, Хөвөөт цагаан хошууны Сайшингаа гэдэг хүн зохиож дуулсан (У Жин И, 2010, 49) бол даруй хагас зууны тэртээ Н.Буяндэлгэр дуулж дэлхий дахинаа алдаршуулсан байна.

Уртын дуучин Н.Буяндэлгэр Барга “Саруул тал” дууг лимбэтэй хослон дуулсан, дууны бүтэц (2+3)+(2+1+3) айзмын хэлбэртэй байна. Хоёр дахь өгүүлбэр гурван фразтай болж, өргөжүүлсэн мөчлөгийн хэлбэртэй байгаа шалтгаан, эхний өгүүлбэрийн шүлгийн “Саруул уул”, “тал минь байвчээ хө” үгс нэг фразанд багтсан бол хоёр дахь өгүүлбэрийн үгс “шавартай”, “тоостой”, “гүүрээгүй-ээ хө” гэж гурван фраз бий болгожээ. Харин аялгууны хэлбэр (a + b)+(c + d + e) хэлбэртэй буюу ихэнх ардын дуунд байдагчлан фраз бүрийн аялгуу давтагдаагүй байна (Зураг 1).

“Саруул тал”

(Барга ардын дуу)

Н.Буяндэлгэрийн дуулснаар

Саруул тал минь байвч
Шавартай намгийг нь гүүрээ үгүй.
Сайхан амраг минь байвч
Санааг нь ердөө гүүрээ үгүй.

Са - аа руу уул та-ал ми нь бай вчээ ээ - ээ
хө - өө Ша вар - тай - ай аа тоос- той
ээ - ээ ээ-ээ мо од үгүйээ ээ хө хө хө

Зураг 1. Н.Буяндэлгэр дуулсан “Саруул тал” дууны Барга хувилбар

Дууны цараа бага наймцын “соль”-с хоёрдугаар наймцын “мибемоль” (g-es²) хүртэл наймц давсан зургаац, өмнө үзсэн дуунуудтай ойролцоо цараа юм. “Саруул тал” дууны аялгуу доод чалханд эхлээд, өгүүлбэр бүрд нэг нэг өгсөөд уруудах давлагаан маягийн хөдөлгөөн үүсгэж, доод чалханд хүрч дуусжээ. Оргил эгшиг дээд туслах эгшиг мэт хоёрдугаар өгүүлбэрийн эхний /с/ фразад дуулагдах тул дээд оргил эгшигийг удаан баригдаж дуулагдах хоёрдугаар наймцын “до” гэж үзэж болно. Харин эхний /а/ фразад дуурьсах “ре” дууны агуулгын оргил буюу оросоор “кульминация” гэж нэрлэгдэх эгшиг юм. “До” оргил эгшиг сүүлийн /е/ фразас

бусад фраз бүрд дуурьсаж буй нь өгүүлбэрүүдийн давлагаалах хөдөлгөөний оргил болж байгаатай холбоотой юм. Ингэж хоёр аялгууны давлагаан үүссэн нь шүлгийн мөр бүр өөрийн бие даасан агуулга илэрхийлж буйтай холбоотой байна. Эхний фразад л дөрөвцөөр өгсөх үсрэлт оргил эгшигт хүргэсэн нь дууны өндөр хурдтай эрчмийг агуулах бөгөөд энэ хөдөлгөөн “уул” гэсэн үгэнд хүргэж буй нь ч энэ хүчдэлийг төрүүлжээ гэж үзэж болно (*Зураг 2*). Харин хоёрдугаар /b/ фразад дараалан дуурьсах уруудсан тавц, өгссөн зургаац, уруудсан долооцын үсрэлтүүд аялгууг уран тансаг болгохын зэрэгцээ “тал минь байвчээ хө” үгэнд дуурьсаж байгаатай холбож үзвэл талын сайхан зэрэглээ мэт сэтгэгдэл төрүүлж байна. Харин хоёрдугаар өгүүлбэрийн эхний хоёр /с, d/ фразын дундах уруудсан зургаац үсрэлт “шавартай”, “гоостой” гэх хоёр үгийг тусгаарлахын зэрэгцээ фраз бүрийг тусгаарлах тод зааг болжээ. Харин төгсгөлд байгаа тавц, дөрөвцийн уруудсан үсрэлт дууны дуусгаврын хэв шинжийг үзүүлж байна. Энэ дуунд бидний “хаялга” гэж нэрлэсэн фразын төгсгөлийн аялгын хөдөлгөөн дөрөв дэх /d/ фразаас бусад фразад байгаа нь энэ “Саруул тал” дууны хувилбар, жинхэнэ Барга хувилбар болохыг давхар нотолж байна.



Зураг 2. “Саруул тал” дууны эхний өгүүлбэр

“Саруул тал” дуу “Үхэрт хүйтэн”, “Сэтгэлийн дугаа намдаа өргөө” дуунууд шиг хөг солигдолтой дуу юм. Эхний фразын эгшгийн эгнээ “соль”, “сибемоль”, “до”, “ре”, “фа,” (g, b, c, d, f *Зураг 2 а*) гэсэн “соль” суурьтай таванэгшигтийн II төрөл бол, хоёрдугаар фразаас зэрэгцүүлэлтээр шууд хөг солигдон “до”, “мибемоль”, “фа”, “соль”, “сибемоль” (c, es, f, g, b *Зураг 2 б*) таванэгшигтийн “до” суурьтай II төрөл болжээ. Ийм байдлаар зөвхөн нэгэн эгшиг л өөрчлөгдсөнөөр /“ре” эгшгийн оронд “соль” эгшиг нэмэгдэн/ таванэгшигтийн хөг өөрчлөгдсөн маш сайхан аялгууны жишээ “Саруул тал” дуу болжээ.



Зураг 2 а. Н.Буяндэлгэрийн дуулсан “Саруул тал” дууны эхний фразын эгшгийн эгнээ



Зураг 2 б. Н.Буяндэлгэрийн дуулсан “Саруул тал” дууны хоёр дахь фразаас хойших эгшигийн эгнээ

Дуучин Н.Буяндэлгэр энэ дууг дуулахдаа өөрийнх нь дуулсан ихэнх дуунд эгшиглэдэг дээд эгшгүүдийг дуулаагүй боловч дууны яруу сайхан чимэглэн болсон хугалаа, нугалааг уран сайхан илэрхийлэхийн зэрэгцээ дараалсан холын үсрэлтүүдийг цэвэр тунгалаг дуулсан нь сонсогчдын “чихийг баярлуулах” сайхан дууны нэг болгожээ.

Н.Норовбанзадын дуулсан “Саруул тал” дуу: Бид уртын дуучин Н.Норовбанзадын дуулсан “Саруул тал” хувилбарыг ноот бичлэгт буулгахдаа хэмгүй тэмдэглэсэн ба урт баригдах эгшгүүдийг хэсгүүдийн зааг гэж тодорхойлон авч үзвэл, эхний хувилбартай харьцуулахад тав биш дөрвөн (a + b) + (c + d) хуваагдалтай мөчлөг байна. Тухайлбар /фраз/ бүр өөр аялгуунд суурилжээ (Зураг 3).

Саруул тал

Н.Норовбанзад дуулснаар



Зураг 3. Н.Норовбанзадын дуулсан “Саруул тал” дууны хувилбар
(Ноотолсон Дай.Цацрал)

Эхний хувилбарын /Н.Буяндэлгэр дуулсан/ тухайлбаруудтай /фразуудтай/ харьцуулахад аялгууны хөдөлгөөн өөр буюу өөр аялгуутай байна. Эхний хувилбарын адил эхлэлд өгссөн хөдөлгөөн уруудсан байгаа ба хоёрдугаар өгүүлбэрээс энэ хувилбарын эхлэл өгсөөд аажмаар уруудсан хөдөлгөөнтэй боловч сүүлийн фраз мөн өгсөж уруудсан хөдөлгөөнтэйгөөрөө өмнөх хувилбараас өөр байна. Өөрөөр хэлбэл, Н.Буяндэлгэрийн дуулсан “Саруул тал” дууны Барга хувилбар хоёр “давлагаантай” бол Н.Норовбанзад дуулсан “Саруул тал” дууны хувилбар гурван “давлагаантай” байна.

Дууны цараа “с” эгшгээс “f” хүртэл наймц давсан дөрөвц байгаа нь өмнөх хувилбараас гуравцаар бага байна. Оргил “f” эгшиг удаан баригдсан, мөн олон давтагдалтай, сүүлийн фразгаас бусад фразад нийт гурван удаа дуулагджээ. Хамгийн дээд эгшиг болох “ля бемоль” /as/ богино хэмнэлд чимэглэн хэлбэрт дуурьсах тул оргил эгшигт тооцохгүй байж болно. Аялгуу өмнөх хувилбартай адил дууны доод чалханд эхэлж, мөн доод чалханд дуусжээ.

Аялгуу огцом холын үсрэлт хоёрдугаар фразын төгсгөлд уруудсан наймцын үсрэлттэй ба бусад тохиолдолд зургаац, тавц байгаа нь өмнөх хувилбартай ойролцоо боловч үсрэлтийн байршил өөр фразад байгаа нь өөр шинж юм.

Ноот тэмдэглэгээнд түлхүүрийн ард дөрвөн “бемоль” тэмдэглэжээ. Дууны суурь эгшиг “фа” учир эгшигийн дараалал “фа”, “ля бемоль”, “си бемоль”, “до”, “ми бемоль” (f, as, b, c, es *Зураг 4*) эгшгүүдээс тогтсон таван эгшигтийн монгол таван эгшигтийн хоёрдугаар төрөлд боловч өмнөх хувилбар шиг хөг солигдолгүй байна.



Зураг 4. Н.Норовбанзадын дуулсан “Саруул тал” дууны эгшигийн эгнээ

Хоёр алдарт уртын дуучдын дуулсан “Саруул тал” дууны хэлбэрийн товчоон:

Дуу	Н.Буяндэлгэрийн дуулсан “Саруул тал”	Н.Норовбанзадын дуулсан “Саруул тал”
Хэлбэр	Өргөжүүлсэн мөчлөг	Хуваагдалтай мөчлөг
Аялгууны бүтэц	$(a+b+c)+(d+e)$	$(a + b) + (c + d)$
Цараа	$(ais-fis^2)$: 13	$(c-f^2)$: 11
Таванэгшигтийн төрөл	(ais, cis, dis, eis, gis); -II төрлөөс (dis, fis, gis, ais, cis); -II төрөл	f, as, b, c, es -II төрөл
Дээд оргил, байршил	b, d, e- “fis ² ”	a, b “fis ² ”
Аялгуу дахь холын үсрэлт, байршил	b; ↗ 5, 7, c-d; ↗ 6, e; ↗ 5	б; ↗ 5, c; ↗ 8 ↗ 6, d; ↗ 5

Гурав. Хоёр алдарт уртын дуучны дуулах онцлог шинж

Н.Буяндэлгэрийн дуулсан “Саруул тал” дууны цараа наймц давсан зургаац цараатай багтаамжтай юм. Дуучин Н.Буяндэлгэр энэ дууг дуулахдаа өөрийнх нь дуулсан ихэнх дуунд эгшиглэдэг дээд эгшгүүдийг дуулаагүй боловч дууны яруу сайхан чимэглэн болсон хоолойн нугалааг уран сайхан илэрхийлэхийн зэрэгцээ дараалсан холын үсрэлтүүдийг цэвэр тунгалаг цайруулж дуулсан нь сонсогчдын “чихийг баярлуулах” сайхан дууны нэг болсон бөгөөд түүний өөрийнх нь онцлог шинж гэж үзэж болно.

Харин Н.Норовбанзад нь Н.Буяндэлгэрийг бодвол дууны цараа гуравцаар бага хэдий ч оргил “f²” эгшиг удаан баригдсан, мөн олон давтагдалтай, гурван удаа дуулагдаж байгаа нь дууны дотоод мөн чанар болон дууг хөгжүүлэн баяжуулахад маш их ач холбогдолтой. Дуулах талдаа дуундаа уусан шингэж дуулах буюу хоолойныхоо багтаамжийн хэрээр дууг урлан тэлж, олон жижиг нугалаа хугалаа, амьсгааны хөдөлгөөн, бөөрөнхийлэх, хатгах зэрэг онцлогтой дуулдаг гарамгай том дуучид гэж үзлээ. Алдарт уртын дуучид нь адилхан тунгалаг сопрано хоолойтой боловч дуулах арга барилын хувьд нэлээд ялгаатай. Учир нь үндэстэн угсаатны болон нутаг нутгийн дуулах арга барилууд ялгаатай өөрийн дэг онцлогтой байдаг.

Н.Буяндэлгэр нь Барга ардын уртын дууны дуулах дэг барилаар дуулдаг бол Н.Норовбанзад нь боржигон болон төв халх аялгуугаар дуулдаг билээ. Ийнхүү өөрсдийн дуулах дэг барилаараа өөр өөрийн онцлогтой “Саруул тал” дууг бүтээжээ.



Зураг 5. 1957 он. Улаан театрт алдарт морин хуурч Сандүүрэн хөгжимдөж Н.Буяндэлгэр, Н.Норовбанзад нар дуулж байгаа нь

Дүгнэлт

Харьцуулан судалсны үр дүнд Өвөр Монголын Барга хэв намбын голлох төлөөлөгч болсон алдарт уртын дуучин Н.Буяндэлгэр болон Монгол улсын Хөдөлмөрийн баатар, Ардын жүжигчин, Төрийн шагналт уртын дуучин Н. Норовбанзадын дуулсан хувилбаруудыг харьцуулахад, хоёр дуучны хоолойн эгшиглээ тун ойролцоо юм. Бүтцийн хувьд “ойролцоо” /5 болон 4 фраз/, утга агуулгын хувьд нэг их зөрүүгүй, царааны хувьд мөн “ойролцоо” /гуравцын ялгаатай/, эгшиглэгээний хувьд “адилавтар” /хөг солигдолтой болон солигдолгүй/, Н.Буяндэлгэр дан хоолойн нугалааг хийж дуулсан бол Н.Норовбанзад олон жижиг нугалааг хийж дуулсан ба тухайлбар бүрийн аялгууны хувьд ондоо байгаа нь дууны дуулагдах хязгаар, нутгийн онцлог, хүн ардын дуулах уран сайхны хандлагын онцлогоос шалтгаалан ондоошжээ гэж үзлээ. Энэ нь цаашид суралцах хоёр орны судлагч оюутнууд, уртын дууны судалгаанд зохих хувь нэмэр болно гэж үзэж байна.

Ашигласан материалын жагсаалт

1. Жанцанноров, Нацаг. 2005. *Уртын дууны уламжлалт зарим нэр томъёоны гаргалгаа*. Улаанбаатар, Монгол улс.
2. Жанцанноров, Нацаг. 1996. *Хөгжмийн онолын нэр томъёоны хураангуй тайлбар толь*. Улаанбаатар. Монгол улс.
3. Норовбанзад, Намжил. 2016. *Дуулим хорвоод дуулах гэж төрсөн минь*. Улаанбаатар. Монгол улс.
4. У Жин И. 2010. *Дундад улсын монгол үндэстний уртын дууны өлгий*. Хөх хот. БНХАУ: Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо.
5. Өвөр Монголын Хөлөнбуйрын радио телевизийн хороо. 2016. *Уртын дууны хатан хаан Н.Буяндэлгэрийн баримтат кино*.